

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 6 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар141

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Компанийн тухай хуулийн 66.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэх тухай” журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг баталсантай холбогдуулж Үнэт цаасны хорооны 1999 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 78 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмыг нийтэд сурталчлан хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ЗАР МЭДЭЭГ ХҮРГЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид “Хороо” гэх/ хувьцаат компанийн /цаашид “компани” гэх/ хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зар мэдээг хурал зарлагч этгээд хувь нийлүүлэгчдэд хүргэх, хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэлийг Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэх, хурал зарлах эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Хурал зарлах эрх

2.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал /цаашид “хурал” гэх/ байх бөгөөд хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.

2.2. Ээлжит хурлыг компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ны дотор зарлан хуралдуулна. Энэ хугацаанд ээлжит хурлыг зарлаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болж хурал зарлах бүрэн эрх хяналтын зөвлөлд шилжинэ. Хяналтын зөвлөл хурал зарлах бүрэн эрх шилжсэнээс хойш ажлын 15 хоногийн дотор зарлах үүрэгтэй. Хяналтын зөвлөл энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд уг компанийн аливаа нэг хувь нийлүүлэгч хурлыг зарлахыг шаардаж шүүхэд хандах, эсхүл өөрөө зарлан хуралдуулж болно. Энэ тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлах, хуралдуулах зардлыг компани гаргана.

2.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл Компанийн тухай хуулийн 60.3., 62.7-д заасан этгээд /цаашид “хурал зарлагч этгээд” гэх/ хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргана.

2.4. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараахь зүйлийг заана:

2.4.1. хурал хуралдах газар, өдөр, цаг;

2.4.2. хурлын хэлэлцэх асуудал;

2.4.3. хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

2.4.4. хуралд бэлтгэх явцад хувь нийлүүлэгчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, цаг;

2.4.5. санал авах хуудсын агуулга;

2.4.6. санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн өдөр;

2.4.7. хурал хуралдуулах тухай хувь нийлүүлэгчдэд мэдэгдэх өдөр, журам.

2.5. Хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.

2.6. Хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг гаргах “бүртгэх өдөр”-ийг хурал хуралдуулах тухай зарыг мэдээлсэн өдрөөс хойш 4 дэх өдөр байхаар тогтооно.

2.7. Хурал зарлагч этгээд нь хурал хуралдуулах тухай шийдвэрээ гаргаснаас хойш 5 хоногийн дотор “Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл”-ийг 1 дүгээр хавсралтын дагуу Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д /цаашид “Бирж” гэх/ ирүүлнэ. Дээрх мэдэгдлийг Хороо, Биржид ирүүлэх хугацаа нь хурлын зарыг нийтэд хүргэх өдрөөс өмнө байна. Мэдэгдэлд дараахь материалыг хавсаргана.

2.7.1. хурал зарлагч этгээдийн хурал хуралдуулах тухай шийдвэр;

2.7.2. хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээлэх зарын загвар;

2.7.3. саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь Компанийн тухай хуулийн 67.1.,67.2-т заасны дагуу хурлын хэлэлцэх асуудалд санал оруулсан бол түүний хуулбар:

2.7.4. хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа:

2.8. Үнэт цаасны хадгаламжийн байгууллагаас бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтанд орсон хувь нийлүүлэгч нь хуралд оролцох эрх эдэлнэ.

2.9. Төлөөлөн удирдах зөвлөл үнэт цаасны хадгаламжийн байгууллагаас бичгээр ирүүлсэн мэдээллийг үндэслэн хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн бүртгэлд өөрчлөлт оруулж болно.

2.10. Хувь нийлүүлэгч нь Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн хуралд оролцож болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа хурлын бүртгэл явагдаж байх үед төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдсэн байна.

2.11. Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд, шинэ эзэмшигч этгээдэд хуралд оролцох итгэмжлэл олгох, эсхүл уг шинэ эзэмшигч этгээдийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.

2.12. Компани нь хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын материалыг гаргасан шийдвэрийн хамт 6 дугаар сарын 1-ний дотор, ээлжит бус хурлын материалыг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор Хороонд ирүүлэх үүрэгтэй. Хуралтай холбоотой аливаа маргаан гарсан тохиолдолд Хороонд ирүүлсэн хурлын мэдэгдэл, хурлын материал, түүнээс гарсан шийдвэрийг эх хувь болгон ашиглана.

2.13. Компанийн тухай хуулийн 60.3 болон энэ журмын 2.2-т заасан хугацаанд компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хурлыг зарлан хуралдуулаагүй бол тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болно. Бүрэн эрх нь дуусгавар болсон төлөөлөн удирдах зөвлөл болон түүнээс томилогдсон гүйцэтгэх удирдлагын аливаа шийдвэр нь эрх зүйн үр дагавар үүсгэхгүй.

ГУРАВ. Хурлын зар мэдээг хувь нийлүүлэгчдэд хүргэх

3.1. Хурал зарлагч этгээд энэ журмын 2.4-т заасны дагуу хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт Хороо болон Биржид хүргүүлсний дараа хурлын тухай зар мэдээг хувь нийлүүлэгчдэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

3.2. Хурал зарлагч этгээд хурлын зар мэдээг хурал хуралдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө өдөр тутам хэвлэгдэн гардаг бөгөөд хамгийн олон хувиар хэвлэгдэж, орон нутагт тараагддаг 2-оос доошгүй сонин болон орон даяар нэвтрүүлгээ түгээх эрх бүхий радио, телевизээр нийтэд мэдээлнэ. Энэ мэдээллийг дээрх хэлбэр, шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор дахин мэдээлнэ.

3.3. Хурал зарлагч этгээд нь хурлын зар мэдээг энэ Журмын 3.2.-т зааснаас гадна утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувь нийлүүлэгчдэд хүргэж болно.

3.4. Хурлын зар мэдээнд дараахь зүйлийг заавал тусгана:

3.4.1. компанийн оноосон нэр, байршил;

3.4.2. хурал хийх өдөр, цаг, газар;

3.4.3. бүртгэх өдөр;

3.4.4. хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;

3.4.5. хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, цаг:

3.4.6. хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь.

3.5. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл, протокол үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган хурлыг хойшлуулна. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг түүнтэй холбогдсон материалын хамт Хороонд ажлын 4 хоногт багтаан ирүүлнэ.

3.6. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын 7 ба түүнээс дээш хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг энэ журмын 3.2-т заасан хэлбэр, шаардлагын дагуу дахин мэдээлнэ. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.

3.7. Хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэж болохгүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хэлэлцэх асуудлыг нэмж оруулах журмыг компанийн дүрэмд зааж болно. Хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн бол тухайн асуудлаар гаргасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.

3.8. Энэ журмын 3.2., 3.4-т заасан журмыг зөрчиж хуралдсан бол хурлыг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл болно.

3.9. Хувь нийлүүлэгчдээс саналын хуудсаар санал авах ажиллагааг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан зохион байгуулж, хурлын баримт бичиг, саналын хуудсыг хурлын тухай зар мэдээг олон нийтэд хүргэхээс 7-гоос доошгүй хоногийн өмнө уг байгууллагад хүргүүлсэн байна.

3.10. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зар мэдээг нийтэд зарлах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө, бүртгэх өдрөөр тасалбар болгон гаргасан хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтын дагуу санал

авах хуудсыг хурал хуралдахаас 15-аас доошгүй хоногийн өмнө тус тус хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компанид хүргүүлсэн байна.

3.11. Хурлын зар мэдээг нийтэд хүргэх үед хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичиг, санал авах хуудсыг бэлэн болгосон байх бөгөөд хувь нийлүүлэгчдэд түүнтэй танилцах боломжийг хурал зарлагч этгээд хангасан байна.

3.12. Ээлжит хурлыг хуралдуулахаар зарласан үед хувь нийлүүлэгчдэд дараахь баримт бичгийг танилцуулна.

3.12.1. компанийн санхүүгийн жилийн тайлан;

3.12.2. санхүүгийн жилийн тайлангийн талаархи аудиторын дүгнэлт;

3.12.3. санхүүгийн өмнөх жилд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий болон их хэмжээний хэлцлүүд, тэдгээр нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн тухай аудиторын дүгнэлт;

3.12.4. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;

3.12.5. нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;

3.12.6. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин урамшуулал;

3.12.7. компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан;

3.12.8. компанийн хяналтын зөвлөлийн тайлан;

3.12.9. шинээр болон нэмж үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлцэх бол гаргах үнэт цаасны төрөл, тоо, нэрлэсэн үнэ, санхүүжилтийн зориулалтын талаар болон хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувь нийлүүлэгчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл.

3.13. Ээлжит бус хурлыг хуралдуулахаар зарласан үед хувь нийлүүлэгчдэд дараахь баримт бичгийг танилцуулна.

3.13.1. ээлжит бус хурал хуралдуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр, үндэслэл;

3.13.2. хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал тус бүрээр гаргах шийдвэрийн үндэслэл, холбогдох мэдээ, тооцоо, судалгаа, танилцуулга;

3.13.3. гарах шийдвэрийн төсөл;

3.14. Хурлыг хувьцаа эзэмшигчид бүрэн багтахаар байранд зохион байгуулахаас гадна хурал хуралдах өдрийг аль болох ажлын бус өдөр зохион байгуулна.

3.15. Компанийн ерөнхий захиргаа байрлаж байгаа газраас өөр газарт хурлыг хуралдуулахаар товлосон бол хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн хамгийн их төвлөрөлтэй, аливаа зардал, чирэгдэлгүйгээр оролцох боломжтой газарт хурлыг хуралдуулна.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1. Шаардлагатай гэж үзвэл хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хүртэл хугацаагаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 37.2.3-т заасан арга хэмжээ авна.

4.2. Энэ журмын 3.2, 3.4-д заасан журмыг зөрчиж хуралдсан хурал болон 3.7-д заасан журмыг зөрчиж гаргасан хурлын тухайн шийдвэрийг Үнэт цаасны гүйлгээний

хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг Үндэслэн Үнэт цаасны газрын дарга, улсын ахлах байцаагч хичингд тооцно.

4.3. Энэ журмын холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.1.1 дэх хэсэгт заасан захиргааны шийтгэл ногдуулна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

“Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн ихурлын зар мэдээг хүргэх тухай” журмын хавсралт

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр

Хаяг, утас

Хурал хуралдах огноо, цаг, газар

.....

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо

.....

Олон нийтэд зарлах огноо

.....

Бүртгэх өдөр

.....

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо

.....

Хүргүүлсэн огноо

Хурлын баримт, бичгийн хуудсын тоо ширхэг, хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

КОМИССЫН ДАРГА /...../

..... оны дүгээр сарын –ний өдөр

.....

ХҮЛЭЭН АВСАН :

БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН /...../

..... оны дүгээр сарын –ний өдөр

.....

Дээрх мэлээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус ирүүлнэ